



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Чингис хот

2025 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6.1, 34.6.2, 34.6.3, 34.6.4 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/675 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны цэргийн бүртгэлийг 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал сумын хэмжээнд зохион байгуулж явуулсугай.

2.Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Лхагвабаатар- Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Хэрлэн багийн Засаг дарга
Хэрлэн багийн Зохион байгуулагч
Булаг багийн Засаг дарга
Булаг багийн Зохион байгуулагч
Баянмөнх багийн Засаг дарга
Баянмөнх багийн Зохион байгуулагч
Сариг багийн Засаг дарга
Сариг багийн Зохион байгуулагч
Өндөрхаан багийн Засаг дарга
Өндөрхаан багийн Зохион байгуулагч
Цогт-Өндөр багийн Засаг дарга
Цогт-Эрдэнэ багийн Зохион байгуулагч
Өлзийт тосгоны Засаг дарга
Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны дарга
Тахилгат тосгоны Засаг дарга
Тахилгат тосгоны ХАА-н мэргэжилтэн

3.Цэргийн үүрэгтэн иргэдийг биечлэн болон цахимаар бүртгэж, 2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, тоо бүртгэлийн материал, мэдээ, судалгааг тогтоосон хугацаанд аймгийн Цэргийн штабт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн дарга (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР